



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 09 -ны өдөр

Дугаар А/114

Эрдэнэт

Чанарын менежментийн хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 265 дугаар тогтоолын "Төрийн байгууллагад чанарын удирдлагын тогтолцоо олон улсын ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.5, 2.8, 3.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2019 оын А/143 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Чанарын менежментийн хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу ажлыг эрчимжүүлэх, нийт ажилтан, албан хаагдыг идэвхтэй оролцуулахыг хорооны дарга, гишүүдэд даалгасугай.
3. Уг тушаал батлагдсантай холбоотой ЭМГ-ын даргын 2021 оны А/105 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болгосонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

12 дугаар сарын 09 өдрийн А/ийн дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

№	Дарга		Эрүүл мэндийн газрын дарга	
	Багууд	Ахлагч	Зохицуулагч	Гишүүд
1	Нэгдүгээр	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн
2				Эрүүл мэндийн статистик, бүртгэл мэдээний сан хариуцсан ажилтан
3				Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
4				Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, осол гэмтлийн тандалт хариуцсан ажилтан
5				Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
6				Нярав
7	Хоёрдугаар	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
8				Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
9				Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт
10	Гуравдугаар	Дархлаажуулалт зоонозын асуудал хариуцсан мэргэжилтэн	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан	Эх, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
11				Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан
12				Даргын туслах, бичиг хэрэг хариуцсан ажилтан
13				БЗДХ, гэдэсийн халдварт өвчний хариуцсан мэргэжилтэн
14	Дөрөвдүгээр	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
15				Амьсгалын зам, сүрьеэгийн халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан ажилтан
16				Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, байгууллагуудын үйл ажиллагааны автоматжуулалт, сүлжээ хариуцсан мэргэжилтэн